



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 1 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

Засгийн газрын 2021 оны зээллэгийн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Өрийн удирдлагын тухай хуулийн 8.1.6, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын 2021 оны зээллэгийн төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР



Засгийн газрын 2021 оны 16 дугаар
тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ЗЭЭЛЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн энэхүү зээллэгийн төлөвлөгөөг боловсруулав.

1. Засгийн газрын 2021 оны санхүүжилтийн хэрэгцээ

1.1. Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 4 болон 7 дугаар зүйлд заасны дагуу Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,938.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар батлагдсан.

1.2. Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2021 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын гадаад, дотоод зээллэгийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,880.3 тэрбум төгрөг байхаар зааснаас 2020 онд гаргахаар төлөвлөсөн дотоод үнэт цаасны 2021 онд төлөхөөр төлөвлөсөн үндсэн төлбөрийн хэмжээгээр буурч 1,526.7 тэрбум төгрөг байна.

1.3. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн дүнг оруулан тооцооноор Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ 2021 онд 3,465.5 тэрбум төгрөг байна.

1.4. Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн задаргааг дараахь хүснэгтээр харуулав:

Хүснэгт 1: Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ

№	Санхүүжилтийн хэрэгцээ	Дүн (тэрбум төгрөг)
1.	Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	8,737.8
2.	Нийт зарлага ба цэвэр зээл	10,676.6
3.	Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (1-2)	1,938.8
4.	Дотоод үндсэн төлбөр	216.0
5.	Гадаад үндсэн төлбөр	1,310.7
6.	Нийт санхүүжилтийн хэрэгцээ (3+4+5)	3,465.5
6.1.	Гадаад төслийн зээлээр санхүүжих	1,265.1
6.2.	Гадаад хөтөлбөрийн зээлээр санхүүжих	296.0
6.3.	Дотоод үнэт цаасны гаргалт	1,840.2
6.4.	Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс санхүүжих	64.2

7.	Алдагдал санхүүжүүлэх өрийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт (6.1+6.2+6.3-4-5)	-1874.6
----	--	---------

1.5.Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээний 1,561.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Засгийн газрын гадаад төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлээр, 1,840.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалан бүрдүүлэхээр тооцоолов.

1.6.Гадаад зээл, гадаад үнэт цаас, дотоод үнэт цаас зэрэг өрийн хэрэгслийн цэвэр өөрчлөлт Хүснэгт 1-д заасны дагуу 1,874.6 тэрбум төгрөг ба барих-шилжүүлэх концесс, Засгийн газрын өрийн баталгааны цэвэр өөрчлөлт болон ханшийн өөрчлөлтийг тооцсоноор Зээллэгийн төлөвлөгөөний 3.2-т заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан Засгийн газрын өр нэмэгдүүлэх дээд хэмжээнд нийцэхээр байна.

2.Засгийн газрын 2021 онд шинээр хийх зээллэгийн төлөвлөгөө

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хүрээнд 2021 онд шинээр хийх зээллэгийг өрийн хэрэгсэл тус бүрээр тодорхойлов.

2.1.Дотоод үнэт цаас

2.1.1.Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3-12.1.4 дэх заалтад заасан зориулалтын дагуу нийт 1,840.2 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаасыг гаргана.

2.1.2.Засгийн газар Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2-т заасан зориулалтаар гаргах үнэт цаасны хэмжээ нь тухайн оны төсвийн улирлын чанартай орлогын дутагдлын хэмжээ болон тухайн оны батлагдсан хүүгийн зардлаар хязгаарлагдана.

2.1.3.Засгийн газрын 2021 онд шинээр гаргах дотоод үнэт цаасны төлөвлөгөөг дараахь хүснэгтэд харуулав:

Хүснэгт 2: Засгийн газрын 2021 онд гаргах дотоод үнэт цаасны төлөвлөгөө

№	Дотоод үнэт цаасны зориулалт	Үнэт цаасны төрөл (хугацаагаар)	Гаргах боломжит хугацаа	Гаргах дээд хэмжээ (тэрбум төгрөг)	Улирлын гаргах дээд хэмжээ (тухайн зориулалтын дагуу гаргах дээд хэмжээний хувь, өссөн дүнгээр)
1.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.1)	Богино хугацаат	3 сар, 6 сар, 9 сар, 1 жил	1,179.4	I улирал-12% II улирал-29% III улирал-54% IV улирал-100%
		Дунд, урт хугацаат	2 жил, 3 жил, 5 жил, 10 жил	294.8	
		Нийт		1,474.2	

2.	Төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.2)	Богино хугацаат	3 сар, 6 сар, 9 сар	Төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлаас хамаарах бөгөөд тухайн оны батлагдсан хүүгийн зардлаар хязгаарлагдана.	I улирал-35% II улирал-75% III улирал-100%
3.	Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих (ӨУТХ 12.1.3)	Богино, дунд, урт хугацаат	3 сараас 10 жил хүртэл	нэг удаагийн арилжаанд 5.0	I улирал-25% II улирал-50% III улирал-75% IV улирал-100%
				Нийт 150.0	
4.	Өрийг дахин санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.4)	Богино, дунд, урт хугацаат	3 сараас 10 жил хүртэл	760.6	Зах зээлийн нөхцөл байдал, зардал эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно.

2.1.4. Засгийн газрын дотоод үнэт цаасыг энэхүү зээллэгийн төлөвлөгөө болон "Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам"-д нийцүүлэн нээлттэй болон хаалттай хэлбэрээр арилжаална.

2.1.5. ЗГДҮЦ-ны үлдэгдэл 2021 онд нэмэгдэх дээд хэмжээ 1,840.2 тэрбум төгрөг байна.

2.2. Гадаад үнэт цаас

2.2.1. "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т заасны дагуу гадаад үнэт цаасыг зөвхөн дахин санхүүжилтийн зорилгоор гаргах бөгөөд гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг хийсний үндсэн дээр гадаад үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авч болно.

2.2.2. Засгийн газар өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд олон улсын зах зээлд арилжаалах гадаад үнэт цаасны дээд хэмжээ 1.0 тэрбум ам.доллар байх бөгөөд гадаад үнэт цаас арилжаалах үйл ажиллагааг тухай бүр холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.

2.2.3. Засгийн газрын гаргах гадаад үнэт цаасны мэдээллийг доорх хүснэгтэд харуулав:

Хүснэгт 3: Засгийн газрын 2021 онд гаргах гадаад үнэт цаасны төлөвлөгөө

№	Дотоод үнэт цаасны зориулалт	Үнэт цаасны төрөл (хугацаагаар)	Гаргах боломжит хугацаа	Гаргах дээд хэмжээ	Арилжаалах улирал
1.	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.1)	-	-	-	-
2.	Өрийг дахин санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.4)	Дунд болон урт хугацаат	5-30 жил хүртэл	1.0 тэрбум ам.доллар	Зах зээлийн нөхцөл байдал, зардал эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно.
3.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх (ӨУТХ 12.1.5)	-	-	-	-
4.	Гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх. (ӨУТХ 12.1.6)	-	-	-	-

2.2.4.Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2021 онд 68.4 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

2.3.Гадаад зээл

2.3.1.Засгийн газар гадаад хөнгөлөлттэй зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 1,265.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй төслийн зээл, 296.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хөтөлбөрийн зээлийг олон улсын байгууллага, хоёр болон олон талт хөгжлийн түншүүдээс авна.

2.3.2.Засгийн газрын шинээр авах гадаад төслийн зээлийн задаргааг дараахь хүснэгтээр харуулав:

Хүснэгт 4: Засгийн газрын 2021 онд шинээр ашиглах гадаад зээлийн төлөвлөгөө

№	Зээлдүүлэгч улс/ байгууллага	Зээлдүүлэгч банк/ байгууллага	Гэрээ байгуулагдсан огноо	Хугацаа	Хүү	Дүн (сая₮)
1.Нэн хөнгөлөлттэй зээл						188,617.86
1.	Бүгд Найрамдах Австри Улс	Raiffessen Банк, UniCredit банк	2016.09.27	18 жил	0 хувь	20,282.61
2.	Азийн хөгжлийн банк	Азийн хөгжлийн банк	2011.09.09	25-32 жил	2%, Libor+0.5%	2,100.00
3.	Бүгд Найрамдах	БНСУ-ын ЭКСИМ банк	2012.05.17	30-40 жил	0.1%-0.2%	18,624.25

	Солонгос Улс					
4.	Бүгд Найрамдах Франц Улс	Натиксис банк	2008.06.05	25-40 жил	0.01%-0.9%	110,189.54
5.	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	БНЭУ-ын ЭКСИМ банк	2012.02.14	25 жил	0.75%	5,638.20
6.	Бүгд Найрамдах Польш Улс	БНПУ-ын Засгийн газар	2017.06.19	28 жил	0.15%	1,666.58
7.	Унгар Улс	БНУУ-ын ЭКСИМ банк	2016.01.25	17.5 жил	0%	10.00
8.	Холбооны бүгд Найрамдах Герман Улс	ХБНГУ-ын Сэргээн босголт хөгжлийн банк	2007.12.21	30-40 жил	0.75%-2.0%	3,361.96
9.	Япон Улс	Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага	2014.01.30-2015.06.05	20-40 жил	0.1%-0.3%	26,744.72
2.Хөнгөлөлттэй зээл						1,076,514.05
1.	Азийн хөгжлийн банк	Азийн хөгжлийн банк	2011.01.27	18-25 жил	2%, Libor+0.5%	418,747.08
2.	Бүгд Найрамдах Беларус Улс	БНБУ-ын Хөгжлийн банк	2019.09.12	18-25 жил	2%, Libor+0.5%	31,300.48
3.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	БНХАУ-ын ЭКСИМ банк	2014.08.21	20 жил	2%	232,396.47
4.	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	БНЭУ-ын ЭКСИМ банк	2016.04.28	25 жил	1.75%	193,938.26
5.	Дэлхийн банк	Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк	2015.07.31	25 жил	1.88%-2%	123,781.64
6.	Европын сэргээн босголт хөгжлийн банк	Европын сэргээн босголт хөгжлийн банк	2018.05.09	15-18 жил	Libor+1%	46,630.00
7.	Европын хөрөнгө оруулалтын банк	Европын хөрөнгө оруулалтын банк	2014.06.30	25 жил	Libor	23,308.73

8.	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	2017.03.30	25 жил	2%	6,401.39
9.	Япон Улс	Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк	2016.10.12	3 жил	2.85%	10.00
Нийт						1,265,131.91

2.3.3. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2021 онд нэмэгдэх дээд хэмжээ 1,279.3 тэрбум төгрөг байна.

2.4. Засгийн газрын өрийн баталгаа

2.4.1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т заасны дагуу Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг 2018 оноос нэмэгдүүлэхгүй.

2.4.2. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2021 онд 95.0 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

2.4.3. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл болон шинээр гаргах хэмжээ нь Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд нийцсэн байна.

2.5. "Барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээ

2.5.1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т заасны дагуу Засгийн газар "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээ шинээр байгуулахгүй.

2.5.2. Байгуулагдсан "Барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээний ашиглалт, улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөлтийн дагуу 2021 онд үлдэгдэл 141.3 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

3. Бусад

3.1. Зээллэгийн төлөвлөгөөний дагуу зээллэг хийснээр Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд дараахь түвшинд хүрэхээр төсөөлөлтэй байгаа нь "Засгийн газрын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т заасан зорилтот үзүүлэлтүүдтэй нийцэж байна:

Хүснэгт 4: Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд

Засгийн газрын өрийн багцын үзүүлэлт	2021 оны зорилтот хэмжээ		2021 ХБГ
	Дээд	Доод	
Жигнэсэн дундаж хүү (хувь)	3.8	3.5	3.7

Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа (жил)	Дээд	8.7	8.7
	Доод	8.3	
Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа (жил)	Дээд	8	7.8
	Доод	7.6	
Гадаад валютаар илэрхийлсэн өр (нийт өрд эзлэх хувь)	Доод	88 хувь	89 хувь

3.2.Зээллэгийн төлөвлөгөөний 2.1.5, 2.2.4, 2.3.3, 2.4.2, 2.5.2 дахь заалтын дагуу Засгийн газрын өрийн үлдэгдэл 2021 онд өмнөх оноос 2,815.0 тэрбум төгрөг хүртэл нэмэгдэхээр байгаа нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зээллэгийн дээд хэмжээнд нийцэж байна.

3.3.Зээллэгийн төлөвлөгөөний 2.1.5, 2.2.4, 2.3.3, 2.4.2, 2.5.2 дахь заалтад заасан өрийн хэрэгслийн үлдэгдэл нэмэгдэх хэмжээ гадаад валютын ханшийн өөрчлөлт, "барих-шилжүүлэх" төрлийн концессын гэрээгээр хэрэгжиж байгаа төслийн гүйцэтгэлээс шалтгаалан хэтрэхээр байгаа тохиолдолд Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргалт, гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг бууруулах замаар Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зээллэгийн дээд хэмжээнд нийцүүлнэ.

3.4.Зээллэгийн төлөвлөгөөний 2.3.2 дахь заалтад заасан гадаад хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг дүнг тухайн хөгжлийн түнш байгууллагын санхүүжүүлж байгаа төсөл арга хэмжээний хэрэгжилт болон бусад зайлшгүй нөхцөл байдлыг харгалзан, Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан нийт дүнд багтаан төсвийн тухай хуулийн дагуу шилжүүлэн, зохицуулалт хийж болно.